



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/496

Мандалговь

Төсөл санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8.1.2 дахь заалт аймгийн ИТХ-ын 2017 оны 25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны 15 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 4-ны өдрийн 25 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас "Өсвөрийн волейболын улсын аварга-2018" төслийг дэмжиж, "Монголын волейболын холбоо" ТББ (С.Нэргүйбаатар)-аар гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. "Өсвөрийн волейболын улсын аварга-2018" төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 5,356,800 (Таван сая гурван зуун тавин зургаан мянга найман зуун) төгрөгийг аймгийн 2018 оны ОНХС-ийн "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010574